

**МОНГОЛ, ХЯТАДЫН ОРЧУУЛАГЧДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЭХЛЭЛ:
ХЯТАДЫН ШИЛДЭГ БҮТЭЭЛҮҮДИЙГ МОНГОЛ ХЭЛНЭЭ
ОРЧУУЛСАН НЬ – ЛУ ШЮНЬ-ИЙ БҮТЭЭЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР**

Лю Яцун

«Нэг бүс, нэг зам» олон улсын хөгжлийн судалгааны академи,

Доктор Ph.D, профессор

Email: yacongliu66@gmail.com

Улс хоорондын харилцааны улс төр, эдийн засаг, аж ахуй, нийгэм соёлыг байдлыг судлахад тухайн цагийн тулгуур баримт бичиг тун чухал ач холбогдолтой байдаг бөгөөд 1952 оны 10 дугаар сарын 4-ний өдөр БНМАУ, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгуулсан «Хятад Монголын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр» нь тийм чухал баримт бичиг мөн билээ.

Нэрт түүхэн хүмүүн Ю.Цэдэнбал хэлсэн үгэндээ: *“Бидний байгуулж байгаа гэрээ нь манай улсын ард түмний найрамдалт харилцаа, тэдний шинэ аз жаргалтай амьдралыг цогцлоох шаргуу хөдөлмөр, энх тайвныг сахин хамгаалах болон Америк, Английн тэргүүлэн буй империалист түрэмгийлэгчдийн эсрэг шударга тэмцлийг улам эрчимжүүлж ах дүүгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэхийн төлөө юм”* гэжээ. Энэ бол түүхэн эхлэл чухал үе байлаа.

Монгол судлаач эрдэмтэд Хятадын ард түмний соёлын өв болсон нэрт түүхч, соён гэгээрүүлэгчдийн бүтээлээс өөрийн эх хэл дээр хөрвүүлэн, Хятадын ард түмний улс төр, эдийн засаг, аж ахуй, нийгэм соёлтой танилцан харилцан бие биеэс суралцаар ирсэн билээ. Сүүлийн дөрвөн жилд Хятад хэлнээс Монгол хэл дээр хөрвүүлсэн улс төрийн, түүхэн, утга уянгын, хэл шинжлэлийн ном зохиолууд нэлээдгүй байгаагаас харахад энэ цаг үеийн хятад судлаач, эрдэмтэд, орчуулагчид хоёр улсын харилцаа болон хөрш орнуудын нийгэм соёлын солилцоонд ямар том үүрэг гүйцэтгэж байгаа нь илхэн байна.

Өнөөдөр Монголын ард түмэн их гүрэн гэгдэх Хятадын ард түмний зохиолуудыг өөрийн хэл дээр уншин танилцах боломжийг олгосон олон эрдэмтэн судлаач орчуулагчдад гүнээ талархал илэрхийлэх нь зүйтэй.

Монгол хэлнээ орчуулагдан гарсан Мао Зэдунгийн зохиолууд бол Марксизм-ленинизмийг удирдлага болгосон ХКН ба Хятадын ард түмний баялаг их туршлагатай танилцахад дөхөм болж байдаг бөгөөд нөхөр Мао Зэдунгийн зохиолуудыг 1952 онд хэд хэдэн удаа Монгол хэл дээр олон мянган хувиар тусгай товхимол болон хэвлүүлж байсан байна. Үүнд:

«Ардын ардчиллын диктатурын тухай»

«Практикийн холбогдол»

«Зэрчлийн холбогдол»

1950 оны 6 дугаар сард ХКН-ын Төв хорооны III бүгд хурал дээр илтгэсэн илтгэл болох «Улс орны санхүү, эдийн засгийн байдлыг үндсээр нь сайжруулахын төлөө тэмцэлд» гэдэг зохиолууд хэвлэгджээ.

Хятадын зохиолчдын олон гайхамшигт зохиолууд монгол хэл дээр хөрвүүлэгдэн Монгол хүмүүний мэлмийг мялаасан зарим бүтээлээс дурдвал:

1. Хятадын шинэ хувьсгалт утга зохиолын үндсийг тавигч Лү Шюний

- «Соёлын шинэ армийн их эрэлхэг тугч»
- «А-Кьюгийн үнэн түүх»
- «Галзуу хүний өдрийн тэмдэглэл»
- «Архины мухлагт»
- «Маргааш»
- «Чун и Чжи»
- «Нутаг»
- «Ерөөл»
- «Шархдаж үрэгдсэн нь»
- «Зам» зэрэг бусад олон арван алдарт өгүүллэгүүд монгол хэлнээ хөрвүүлэгдэн хэвлэгдсэн байдаг.

2. Хятадын нэрт зохиолч Жао Шули (赵树理)-гийн «Лижа тосгон хувирсан нь» гэдэг тууж хэвлэгдсэн. Энэ туужийн сэдэв нь Хятадын тосгон, газрын эздийн дарлал боолчлолоос ангижрахын төлөө тариачны тэмцсэн тэмцэл, тосгонд нийгмийн шинэ харьцаа ялсан ялалтыг харуулжээ.

3. Өвөр Монголын зохиолч Малчинхүү «Хорчины тал газрын хүмүүс» гэдэг жижиг тууж 1951 онд хэвлэгдсэн байдаг. Энэ туужид Хорчины тал нутгийн ардууд, Хятадын коммунист нам, дарга Мао Зэдунгийн удирдлагын дор шинэ жаргалант байдлаа баатарлагаар зохион байгуулж, хуучин нийгмийн үлдэгдлийг сонор сэрэмжтэй, хатуу ширүүнээр даран устгаж байгаа явдлыг үзүүлжээ.

4. 1952 онд Монгол хэл дээр «Чөлөөт Хятадын яруу найраг» гэдэг ном хэвлэгдэн гарсан юм. Энэ номд Хятадын хэдэн арван яруу найрагчдын 50 шахам бүтээл оржээ. Энд нэрт зохиолч яруу найрагч Го Мо-жо, Эм сяо, Ай цин, Люй цзянь, Ху Фзи, Чжан Сун-жу, Ян Юй, Цзан Кэ-цзя, Ван я-пин, Яны Чэнь, Тянь-цзянь, Гао лань зэрэг хүмүүсийн шүлгүүд бусад олон арван залуу зохиолчдын шүлэг дуунууд оржээ

5. Жөү Либогийн «Догшин салхи ширүүн бороо» роман болон **эмэгтэй зохиолч Дин Линий** «Сангань мөрөн дээр нар мандав» романуудыг

хэвлэн гаргасан нь хоёр улсын утга уран зохиол оюун боловсролын хамтын ажиллагаа өргөжин тэлснийг харуулж байсан юм.

Хятад хэлнээс номуудыг монгол хэлэнд хөрвүүлэхийн ач холбогдол

Хятад, Монголын улс төрийн, түүхэн, уран зохиол сонгодог бүтээлийг харилцан орчуулж хэвлүүлэх нь:

1. Хоёр ард түмэн бие биеийнхээ соёлыг ойлгож, үнэлэх
2. Улс төрийн хамтын ажиллагааны бат найрамдалт харилцаа үүсэх
3. Соёл оюун санааны хувьд харилцан суралцаж, итгэлцэл бий болох
4. Хоёр орны бүх талын харилцааны ирээдүйн үндэс суурь бэхжих
5. Соёл боловсролын хамтын ажиллагаа төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж хоёр орны судлаач, эрдэмтэд хамтран ажиллах зэрэг олон талын ач холбогдол дүүрэн гэгээн үйлс цацруулсан сайхан ажил билээ.

Энэ цаг үеийн хятад хэлнээс монгол хэл дээр хөрвүүлсэн улс төрийн, түүхэн, утга уянгын, хэл шинжлэлийн ном зохиолуудыг ард түмний мэлмийд хүргэсэн зарим хятад судлаач, эрдэмтэд, орчуулагчдын тухай товчхон дурдвал:

1. Орчуулагч, судлаач МУСГЗ М.Чимэдцэеэ түүний орчуулсан ном бүтээл
2. Орчуулагч, судлаач доктор Д.Болдбаатар түүний орчуулсан ном бүтээл
3. Орчуулагч, судлаач Х.Баатархүү түүний орчуулсан ном бүтээл
4. Орчуулагч, судлаач Б.Гэрлээ түүний орчуулсан ном бүтээл
5. Бусад орчуулагч, судлаачид ба тэдгээрийн орчуулсан ном бүтээл (Мө. Батбаяр, Г. Элдэв-Очир, А.Урантогос)

Орчуулагч, судлаач МУСГЗ М.Чимэдцэеэ

Монголын нэрт нанхиад ч, орчуулагч, профессор Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Күнз судлаач М.Чимэдцэеэ багшийн Хятад-Монгол хоёр улсын хоорондох оюун санааны хөрөнгө оруулалтыг энд дурдаад баршгүй билээ. «Хятадын соёлын мэдлэгийн толь»-ийн монгол орчуулгыг баг хамт олноо удирдан хийж гүйцэтгэсэн. Тэрээр орчуулгын чиглэлээр 20 гаруй жил ажиллаж байгаа бөгөөд Хятадын уламжлалт соёлын сонгодог бүтээлүүд болох

- «Их суртахуй»
- «Зөвшөөрлийн сургаал»
- «Сүнзийн дайтахуйн ухаан»
- «Күнзийн түүхүүд»

- «Мэнзийн сургаал» зэрэг зохиолуудыг орчуулж, олон нийтэд хүргэсэн.

Монголын орчуулгын хүрээлэнгийн тэргүүн тэрээр 2007 оноос хойш МУИС-ийн Күнзийн хүрээлэнгийн Монгол дахь захирлаар ажиллаж, их, дээд сургууль, олон бага, дунд сургуулиудад судалгааны ажлуудыг хийж хятад хэлний сургалтын нөхцөл байдлыг судлан мөн хятад хэлний сургалтыг хөгжүүлэх, орон нутгийн багш бэлтгэхэд туслах, Хятад, Монгол хоёр орны соёлын солилцоог ахиулахад гарамгай хувь нэмэр оруулсан. Түүний зарим бүтээлээс сийрүүлбэл:

- Ши Жиньпин: Төр улсыг засах тухай
- Хятадын сонгодог утга зохиолын дээж дөрвөн бичиг: Мэнз бичиг, Их суртахуй, Хэв дундын ёсон, Сүнзийн дайтахуйн ухаан
- Хятадын соёлын мэдлэгийн толь
- Шүүмжлэл өгүүлэл
- Бидний мэдэх хийгээд эс мэдэх Хятад орон: сэтгэлгээ, соёл
- Күнзийг зургаар өгүүлэхүй
- Destiny Community-Хятад улс ба хөрш орнуудын хувь заяаны цогц нэгдэл

Орчуулагч, судлаач доктор проф Д.Болдбаатар

Монголын нэрт орчуулагч, доктор Д.Болдбаатар багшийн гавьяаг батлан илтгэдэг чухал баталгаа бол БНХАУ-ын төр засгаас түүнд “Хятадын утга зохиолын салбарт онцгой хувь нэмэр оруулсны төлөө шагнал” олгосныг БНХАУ дахь Монголын ЭСЯ-аас гардуулсан байдаг нь түүний нэрийн хуудас болох том тайлбар билээ.

Нэрт орчуулагч Д.Болдбаатар нь Хятадын эртний сонгодог их туурвилууд болох «Гурван улсын үлгэр», «Усан хөвөөний шастир», «Хүйтэн уулын бичиг», «Чонон сүлд» зэрэг 30 гаруй ном, кино, телевизийн бүтээлийг хятадаас монгол хэлнээ хөрвүүлж, монголчуудын хүртээл болгосон юм.

1. Чингис хаан
2. Чонон сүлд
3. Эрлэгийн мөнхрөл
4. Хөхөмдөг үүлт тэнгэр
5. Балар ой
6. Гариг дэлхийн өнийн хэрэг
7. Баруунд зорчсон тэмдэглэл I, II, III боть
8. Усан хөвөөний шастир I, II, III боть
9. Гурван улсын үлгэр I, II, III боть
10. Хувраг бүжиг
11. Дияан

12. Журамт бүсгүй
13. Богд Миларвайгийн зохионгуй тууж ба боловсрол тонилохуй нүр дууллууд
14. Дууны саваа
15. Муухай Хятад хүн

Орчуулагч, судлаач Х.Баатархүү

Орчуулагч Монгол, Хятадын улс төр, нийгмийн харилцааны түүхийн судлаач Х.Баатархүү нь «Хятадын төрийн удирдагч» цуврал бүтээлүүд туурвиж «Жоу Энълай», «Улаанхүү», «Дэн Сяопин» номуудыг гаргасан нь түүний хоёр улсын хамтын ажиллагаанд оруулсан томоохон хувь нэмэр болон ямар жинтэй судлаач болохыг харуулж байна. Түүний хувьд Хятад-Монголын хамтын ажиллагаа, хөгжлийн судалгааны хүрээлэн: синологийн судалгаа, Хятад-Монгол орчуулгын ажил эрхэлсээр ирсэн.

Орчуулсан бүтээлүүд:

- Ши Жиньпиний «Ядуурлаас ангижрахуй»
- «Ядуурлыг бууруулах тухай Ши Жиньпиний хэлсэн үгийн хураангуй»
- «Ардын Ерөнхий сайд Жоу Энълай»
- «Дэн Сяопиний намтар»
- «Улаанхүүгийн намтар»
- Хятад түлхүүр үгс: «Бүс ба Зам санаачилга»
- Хятад түлхүүр үгс: «Засаглал ба удирдлага»
- Хятад түлхүүр үгс: «Төрийн засаглал»
- Хятад түлхүүр үгс: «Шинэ эрин дэх дипломат ажиллагаа»
- Хятад түлхүүр үгс: «Нам байгуулагдсаны 100 жилийн ой»
- Хятад хэлний түлхүүр үг: «Экологийн соёл иргэншил»
- Монгол-Хятадын биеийн тамир, спортын харилцааны түүх
- Орчин үеийн Хятад улсыг ойлгох хөтөч-Шинэ эрин үеийн гадаад харилцаа
- Орчин үеийн Хятад улсыг ойлгох хөтөч-Ядуурлаас оновчтой ангижруулахуй
- Орчин үеийн Хятад улсыг ойлгох хөтөч-ХКН байгуулагдсанаас хойших 100 жилийн түүхэн үйл явдлууд

Орчуулагч, судлаач Б.Гэрлээ

Түүний тухай өөрийн дүгнэлтийг хийхийн оронд өмнө мэргэжлийн сэтгүүлчтэй ярилцсан ярилцлагын хэсгээс энд сийрүүлъя. *“Орчуулга бол уран зохиолын “хар ажил” гэж хүмүүс ярьдаг. Өөр хүний бүтээлийг унаган төрөлх үгсийн сангаараа дахин амилуулж буй тухай тэд гадарлах ч сөхөөгүй. Гэвч энэхүү “хар ажил” үргэлжид “цагаан мөр”-тэй байдаг” хэмээжээ.*

Хятадын анхны Нобелийн шагналт зохиолч Мо Янийн тухай, түүний зохиолын уран сайхан, өвөрмөц бичлэгийн хэлбэртэй эх хэлээрээ танилцахад орчуулагч Б.Гэрлээ чухал үүрэг гүйцэтгэсэн байна. 2019 онд Монгол-Хятад хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойд зориулан гаргасан Хятадын зохиолчдын хоёр ч түүвэр дээр яруу найрагч До.Болдхуягтай хамтарч ажилласан байна.

Түүний орчуулгын бүтээлээс жагсаавал:

1. Чингисийн цагаан үүл
2. Монгол нутгаар зорчсон тэмдэглэл
3. Хиагтаас Гулз хүртэл аялсан минь
4. Буддын шашин
5. Өглөө есөн цагт намайг сэрээ
6. Философийн анхны түүх
7. Хилийн дээснээс урагшхан, алтан нарнаас баруунтаа
8. Туужис 2
9. Туужис 3
10. Ар, Өвөр Монголоор зорчсон тэмдэглэл
11. Боомт хот
12. Харанхуйд
13. Хятад орныг 10 үгээр

Цаашид хоёр улсын соёлын солилцооны хамтын ажиллагаанд чухал хэрэгсэл болсон ном товхимлыг хэвлүүлэн нийтлэх ажил эрчимжих төлөвтэй байна. 2022 оны 6 дугаар сарын 24-нд Хятад, Монгол хоёр орон «БНХАУ-ын Төрийн хэвлэлийн газар, Монголын Соёлын яам хооронд сонгодог бүтээлүүдийг харилцан орчуулах, хэвлэх санамж бичиг»-т гарын үсэг зурсан юм. БНХАУ-ын Төрийн хэвлэл, хэвлэлийн газрыг төлөөлж Суртал ухуулгын төв газрын дэд сайд Жан Жяньчун, Монголын талыг төлөөлж Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилиг нар гарын үсэг зурсан нь энэ ажил улам бүр өргөжин тэлэхийн баталгаа билээ. Санамж бичгийн дагуу Хятад, Монгол хоёр орон ирэх таван жилд хоёр орны сонгодог 50 бүтээлийг хамтран орчуулж, хэвлэн нийтэлж, хоёр орны ард түмэнд оюун санаа, соёлын нэн шилдэг бүтээгдэхүүнээ зориулахаар тохиролцсон байна.

Хятад, Монголын сонгодог бүтээлийг харилцан орчуулж хэвлүүлэх тухай санамж бичигт гарын үсэг зурж, хэрэгжүүлснээр хоёр ард түмэн бие биеийнхээ гайхалтай соёлыг ойлгож, үнэлж, хоёр орны соёлын солилцоо, соёл иргэншлийн харилцан суралцах үйлсийг улам ахиулах болно.

Номын цагаан буян үргэлж дэлгэрэх болтугай.